



МОНГОЛ УЛС  
ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2023 оны 04 сарын 07 өдөр

Дугаар А/212

Хэрлэн сум

Эдийн засгийн чуулган зохион байгуулах  
ажлын хэсэг томилох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Монгол Улсын Их Хурлын 2021 оны 106 дугаар тогтоолоор батлагдсан “Шинэ сэргэлтийн бодлого”-ын 4.3, Засгийн газрын 2022 оны 419 дүгээр тогтоол, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2023 оны Арвандолоодугаар хуралдааны 09 дүгээр тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Улаанбаатар хотоос хөдөө орон нутагт шилжин суурьших, иргэд аж ахуй нэгжийг дэмжих, аймаг орон нутагт шинэ хөрөнгө оруулалт татах, төсвийн орлогоо бие даан бүрдүүлэхэд санхүү, эдийн засгийн боломжийг бий болгох зорилготой “Нээлттэй Хэнтий аймаг” эдийн засгийн чуулганыг зохион байгуулах ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй томилсугай.

Ажлын хэсгийн Ахлагч:	Л.Батсайхан	Засаг даргын орлогч
Нарийн бичиг:	Э.Мөнх-Эрдэнэ	Хөгжлийн бодлого, төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтсийн дарга
Гишүүд:	М.Ганхүлэг	Хэнтий аймгийн Нутгийн зөвлөлийн дэд дарга (зөвшилцсөнөөр)
	Д.Амгаланбаатар	Монгол Улсын Ерөнхий сайдын ахлах зөвлөх (зөвшилцсөнөөр)
	Ж.Гантулга	Төрийн захиргааны удирдлагын хэлтсийн дарга
	Б.Мөнхжаргал	Хөгжлийн бодлого, төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтсийн ахлах мэргэжилтэн
	Б.Оюундарь	Хөгжлийн бодлого, төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтсийн мэргэжилтэн

Х.Эрдэнэгарьд	Хөгжлийн бодлого, төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтсийн мэргэжилтэн
Б.Дархантөр	Байгаль орчин, аялал жуулчлалын газрын дарга
Ж.Энх-Амгалан	Хүнс, хөдөө аж ахуйн газрын дарга
Б.Сүнгээ	Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч
Т.Зулбаатар	Соёл, урлагийн газрын дарга
Д.Батболд	Худалдаа аж үйлдвэрийн танхимын Хэнтий аймаг дахь салбар танхимын дарга
Б.Болд-Эрдэнэ	Политехникийн коллежийн захирлын үүргийг түр орлон гүйцэтгэгч

2. Чуулганы бэлтгэл ажлын төлөвлөгөө, удирдамж, хөтөлбөрийг боловсруулж батлуулан, мэргэжлийн өндөр түвшинд үр дүнтэй зохион байгуулж ажиллахыг Ажлын хэсгийн ахлагч (Л.Батсайхан)-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



Ц.ЧОГСОМЖАВ